



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар

А/39

Амардалай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг
вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, дэх заалт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 01 дүгээр сарын 11 ны өдрийн 05 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Коронавирус (Ковид-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааг суманд зохион байгуулж, хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Гишүүд: Г.Норжмаа /ЭМТ-ийн лаборант/

Л.Отгонбаатар /Сумын Онцгой комиссын гишүүн/

Ш.Отгонцэцэг /Сумын онцгой комиссын гишүүн/

Г.Гэрэлтзун /ЭМТ-ийн их эмч/

Г.Содхүү /ЭМТ-ийн сувилагч/

Нарийн бичгийн дарга: ЭМТ-ийн дарга

Хоёр: Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакциныг татан авчрах, дархлаажуулах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ЭМТ-ийн дарга /С.Батцэцэг/, байнгын бэлэн байр бэлтгэж, иргэдийн халдвар хамгаалалд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын Штабын дарга /С.Нарантунгалаг/, дархлаажуулах арга хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллагыг татан оролцуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулахыг Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав: Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сумын Онцгой комиссыг явцын мэдээллээр хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Л.Золжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

488010 110